

АРДЧИЛЛЫН ХӨГЖИЛ – ИРГЭНИЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН НӨЛӨӨ

М. Одмандах*

* МУБИС-ийн МоСС-ийн Уран зохиолын тэнхмийн багш, докторант.

Түлхүүр үг: Ардчилал, иргэний нийгэм, иргэдийн оролцоо, мэдээлэл, эрх чөлөө, сэтгүүл зүй, иргэний сэтгүүл зүй, үр нөлөө, үүрэг, хариуцлага.

**Ардчиллын тухай
ойлголт**

1. Ардчилсан нийгэм бол иргэд нь төрд үйлчилдэг бус харин төр нь иргэддээ үйлчилдэг нийгэм юм. Иргэдийн оролцоо, идэвхтэй үйл ажиллагаа нь аливаа тулгамдсан асуудлыг төр засгаас шийдвэрлэхэд хүчтэй нөлөөлөх ёстой. Иргэд төрийн эзний хувьд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэн төрийн хэрэгт шууд оролцох эрхтэй. Хуучин нийгмийн үед бид иргэн нь төрдөө үйлчилдэг нийгэмд амьдарч байв. 1992 оны Үндсэн хуулиар манай нийгмийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, бид төр нь иргэндээ үйлчилдэг ардчилсан нийгэмд шилжив. Иргэд өөрсдөө төрөө сонгож, татвар төлөгчийн хувьд өөрсдөө төрөө санхүүжүүлдэг.

"Ил мэдээлэл иргэнийг хүчтэй болгоно", "Иргэн хүчирхэг бол төр хүчирхэг" ч гэж ярьдаг.

Нийгмийн амьдралд иргэдийг идэвхтэй оролцдог болгох нь "Иргэний нийгэм"-ийн өмнө, түүний дотроос "Иргэний сэтгүүл зүй"-н өмнө тулгараад байгаа амин чухал асуудал болоод байна. Иргэдийн

оролцоо гэдэг нь төр засгийн бодлого шийдвэрт нөлөөлөхийг хэлнэ. Иргэд өөрсдийн санаа бодол, үзэл бодлоо төрөөс баримтлах бодлого, амьдралд нийцтэй шийдвэр гаргахад тусгах бүрэн боломжтой.

"Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-ын 19-р зүйлд "... Хүн бүр үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана" гэж баталгаажуулсан байдаг. Энэхүү эрхээ иргэд бүрэн утгаар нь хэрэгжүүлж чадсан үед л ардчилсан нийгэм жинхэнэ утгаараа оршин тогтнож байна гэж үзэх үндэстэй бөгөөд иргэний дуу хоолой хүчтэй байх ёстой.

Ардчилал нь бидний мэддэгээр дөрвөн жилд нэг удаа чөлөөт сонгууль явуулж өөрсдийн эрх барих төлөөллийг сонгосноор дуусгавар болдоггүй юм. Энэ хугацаанд үйл ажиллагаа явуулж буй эрх баригч улс төрийн хүчнүүд ардчиллыг мөн чанараар нь хөгжүүлж байна уу гэдэг асуудал тулгардаг. Эрх чөлөө боогдмол байгаа үед ардчилал хэзээ ч байдаггүй бөгөөд хүмүүсийн дуу хоолой тэр болгон тусгагддаггүй байна. Энэ үед л иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг гарч ирдэг юм.

2. Иргэний нийгэм гэж юу вэ?

Иргэний нийгэм гэдэг нь нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаанд тодорхой зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүй оролцож, албан болон албан бус хэм хэмжээ, жаяг жишгийг тогтоож байдаг хувь хүмүүс, нийгмийн бүлэглэлийг хэлнэ. Орчин үеийн ойлголтоор иргэний нийгэм гэдэгт үйл ажиллагаа явуулж байгаа, зохион байгуулалтын тодорхой бүтцэд орсон бүлэглэлүүдийг хамруулж үздэг байна¹. Эдгээр бүлэглэлүүд нь иргэний нийгмийн үүргийг гүйцэтгэж байдаг. Иргэдийг мэдээллээр хангах, мэдээллийг түгээх үүргийг иргэний сэтгүүл зүйн үйл ажиллагаа хангадаг. Иргэдийн дуу хоолойг байгаагаар нь тусгахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь эдийн засаг, улс төр, монополиудын зүгээс хараат бус байх ёстой. Гэтэл өнөөдрийн манай сэтгүүл зүй засгийн газрын үйл ажиллагааг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн хоёр туйлын байр сууринаас мэдээлэл цацдаг. Энэ нь эргээд ардчилалд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд төр засагт хүрэх иргэдийн дуу хоолой дутагдаж байна.

"Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно..." гэж Үндсэн хуулийн үзэл баримтлалдаа тунхагласан боловч өнөөдөр манай иргэний нийгэм нь өөрийн үзэл бодолгүй, дуу хоолойгүй, дээр

хэлсэнчлэн эерэг, сөрөг үзэл бодлуудыг хамгаалсан, дэмжсэн шинжтэй байна. Өнөөдөр иргэдийн эрх ашгийг хамгаалсан, тэдний үзэл бодлыг тусгасан үзэл бодол дутагдаж байна.

Иргэд нь хоёр талын хэт туйлширсан үзэл бодлыг хүлээн авснаар тэд ч гэсэн өөрсдийн эрх ашгийн үүднээс асуудалд хандахаас илүү тэдгээр улс төрийн хүчнүүдийн нөлөөнд автсан байдал Монголд түгээмэл байгааг хэлэх хэрэгтэй. Энэхүү байдлыг засаж залруулах, иргэдийн эрх ашгийн үүднээс аливаа асуудалд бодитой хандах бололцоог нээж өгөх нь иргэний сэтгүүл зүйн хамгийн гол зорилго юм.

Ардчиллын нэг хэмжүүр нь иргэдийн дуу хоолой төр засагтаа хэр зэрэг хүрч байна, төр засаг нь иргэдэд хамаатай, тэдний эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж байгаагаар хэмжигддэг. Тийм учраас Монгол улсад иргэний нийгэм жинхэнэ утгаараа байхгүй бөгөөд төр засгийн шууд үргэлжлэл болсон ТББ-ууд нь иргэдийн дуу хоолой гэхээсээ илүү улс төрийн хүчнүүдийн болон эрх баригчдын ажил үүргийг хувааж үүрэлцдэг, амьдрах, оршин тогтнох хэрэгсэл болгон ашиглагдаж байна.

3. Иргэний сэтгүүл зүй төлөвшсөн нь

Сэтгүүл зүйн практикт нэлээд олон жилийн өмнөөс иргэний сэтгүүл

«

Иргэдийн дуу хоолойг байгаагаар нь тусгахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь эдийн засаг, улс төр, монополиудын зүгээс хараат бус байх ёстой. Гэтэл өнөөдрийн манай сэтгүүл зүй засгийн газрын үйл ажиллагааг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн хоёр туйлын байр суурьнаас мэдээлэл цацдаг. Энэ нь эргээд ардчилалд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд төр засагт хүрэх иргэдийн дуу хоолой дутагдаж байна.

»

зүйн тухай яригдаж иржээ. АНУ-ын Иргэний сэтгүүл зүйн төвийн гүйцэтгэх захирал Жан Шафэр хэлэхдээ: "...Учир шалтгаан нь сэтгүүл зүйд бус, харин ардчиллын механизм өөрөө зэвэрснээс энэ бүхэн үүдэлтэй юм" гэж тайлбарласан байна. Ардчилал хүчтэй хөгжиж, иргэдийн эдийн засгийн боломж нэмэгдэх хэрээр иргэдийн нийгмийн идэвх, сонгуульд оролцох оролцоо багасан зэрэг нь үүний сөрөг үр дагавар ажээ. Энэ бүх асуудлыг шийдвэрлэхийн тулд иргэний сэтгүүл зүйн тухай ойлголт ХХ зууны сүүлч 90-ээд онд хүчтэй дэлгэрч эхэлсэн байна. Анхандаа АНУ-д төслийн шугамаар хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үр дүн нь өндөр гарч, өнөөдөр АНУ-ын таван редакторын нэг нь иргэний сэтгүүл зүйн зарчмыг баримталдаг болжээ.

1993 онд "Иргэний сэтгүүл зүйн төв" байгуулагдаж энэ чиглэлээр олон төсөл хэрэгжүүлж, 1996 онд төслийн үр дүнгийн судалгаа хийж үзэхэд, зөвхөн Медисонд хэрэгжүүлсэн төслийн үр дүнд иргэдийн идэвх ухамсарт мэдэгдэхүйц ахиц гарсан дүн харагджээ. Тухайлбал, төслийн дараа тэндхийн иргэдийн 40 хувь нь төслийг нэрээр нь мэддэг болж, 52 хувь нь улс төрийн хэрэгт идэвхтэй оролцохын ашиг тусыг ухаардаг болж, мөн тийм хувь нь амьдарч байгаа газраа илүү тохилог сайхан болгохыг удирдагчдаасаа шаарддаг болж, 74 хувь нь нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд саналаа нэмэрлэдэг болж, 64 хувь нь энэ хэрэгт биеэр оролцдог болж, 60 хувь нь сонгуульд саналаа өгөх шаардлагыг гүнээ ухамсарладаг болсон байжээ. Үүнээс үндэслэн иргэний сэтгүүл зүйг нөхцөл байдлыг хувирган өөрчлөгч, бодитой үр дүн гаргагч, нэг үгээр хэлбэл бүтээлч сэтгүүл зүй гэж үзэх болсон байна².

Уламжлалт сэтгүүл зүй нь "түргэн хоол"-ыг улам бүр санагдуулах болжээ. Сэтгүүлч ганц хоёр хүнтэй ярилцах юм уу, утасдаад хэлснийг нь эвлүүлэх, интернэтээс бага сага мэдээлэл олж аваад, сонирхолтой болгох үүднээс ганц нэг жишээ оруулаад л гүйцээ. Энэ нь хүлээн авагчдад бодитой мэдээлэл хүргэх боломжтой боловч зарим талаар хүлээн авагчдын анхаарлыг татахгүй тал байдаг байна. Өнөөдөр манай хэвлэл мэдээллийн хэрэглүүдээр том улс төрчид, бизнесмен, компаниуд болон урлагийнхны тухай, тэдний хувийн амьдралын тухай бичдэг. Энэ нь иргэдийн хувьд зөвхөн зугаа, сонирхол татах зүйл бөгөөд тэдний хувьд ямар ч ач холбогдолгүй, үр нөлөө багатай юм. Хүмүүс өөрт нь хамаатай, хүрээлэн байгаа орчны тухай мэдээлэлд анхаарлаа хандуулах нь илүү, мэдээллийн үр нөлөө нь өндөр байдаг. Мэдээллийн хувьд тэнцвэртэй, иргэдийн эрх ашгийг хөндсөн асуудлыг нээж тавьсан сонин хэвлэл ямагт нэр хүндтэй, эрэлт хэрэгцээтэй байдаг.

Тиймээс иргэний сэтгүүл зүйн зарчим нь жирийн хүмүүс, тэдний тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг хэвлэл мэдээллээр өргөн тусгаж хэлэлцэх замаар тэднийг эхлээд орон нутгийн нийгмийн амьдралыг удирдаж хөтлөхөд идэвхтэй оролцоход түлхэх ёстой. Тэгвэл аяндаа улс орны нийгэм, улс төрийн амьдралд идэвхтэй оролцож эхлэнэ гэж үзэж байна.

Хүмүүс мэдээллийн урсгал буюу сонин хэвлэл, радио, телевизийн нийтлэл нэвтрүүлгийг идэвхгүй хүртэгч байж таарахгүй. Тэднийг зөвхөн бичиж нийтлэх объект биш харин мэдээллийн субъект гэж үзнэ. Уламжлалт сэтгүүл зүйд хэвлэл мэдээллийнхэн уншигч, үзэгч,

сонсогчдод хандсан нэг талын урсгалтай явж ирсэн бол одоо хүлээн авагчдаас сонин руу чиглэсэн хоёр сөрөг урсгалыг нээх ёстой бөгөөд шинэ сэтгүүл зүй нь интерактив байх ёстой гэж иргэний сэтгүүл зүйн талыг дэмжигчид үзэж байна.

4. Иргэний сэтгүүл зүйн тодорхойлолт

Иргэний сэтгүүл зүйг олон хүн янз бүрээр тодорхойлж, жишээ баримтаар тайлбарласан байдаг ч дараах хоёр санааг тэнцүү тусгасан байна. Үүнд:

1-рт: сэтгүүлчид мэдээллийн үйл ажиллагаа явуулахдаа иргэдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг хэвлэл мэдээллээр өргөн хэлэлцүүлэх,

2-рт: иргэд өөрсдөө сэтгүүл зүйн үйл ажиллагаанд идэвхтэй хандаж, өөрт болон бусдад тохиолдсон асуудлыг мэдээлэх замаар хэвлэл мэдээлэл рүү хандах явдал юм.

Тухайлбал, "Лос Анжелос Таймс" сонины Вашингтон дахь товчооны дарга асан Жак Нелсон "Иргэний сэтгүүл зүй гэдэг нь нийгэм дэх бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд ердийн иргэдийг татан оролцуулах нэгэн оролдлого юм"³ гэж тодорхойлсон бол Миннесота муж улсын Олон нийтийн КТСА телевизийн Программын гүйцэтгэх захирал Билл Ханлэй "Иргэний сэтгүүл зүй нь тодорхой асуудлыг ойлгож, шийдвэрлэх арга замуудыг олохын төлөө иргэд ба сурвалжлагчдыг хамтран ажиллах бололцоог бүрдүүлдэг", хэл бичгийн шинжлэх ухааны доктор, профессор Л.Норовсүрэн "Иргэний сэтгүүл зүй юуны өмнө амьдралдаа тохиолдсон чухал асуудлыг мэдээлэхэд идэвхтэй оролцдог сонгогчдын

сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм"⁴ гэж зэргээр тодорхойлжээ. Эдгээр болон бусад тодорхойлолтоос үзэхэд "Иргэний сэтгүүл зүй гэдэг нь түүнийг хөдөлгөгч хүчнүүд болох сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас гадна түүний үйл ажиллагааг амьдралд хэрхэн хэрэгжүүлэх болон нийгэмтэй холбох, мөн үзэгч, уншигчиддаа яаж бүрэн эрх олгох вэ зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдол бүхий цогц юм" гэж ойлгож болно. Мөн иргэний сэтгүүл зүй нь бидний амьдарч буй газар сэтгүүл зүй юу хийж чадах болон олон нийтийн санаа бодол, амьдралд хэрхэн нөлөөлөх тухай үйл ажиллагаа гэж үзэж бас болно.

5. Иргэний сэтгүүл зүйн нөлөө

Өнөөдөр сэтгүүл зүй нь аливаа зөрчил, маргаан дээр тулгуурлаж мэдээлэл түгээдэг. Зөрчилдөгч хоёр талыг зэрэг харуулсан бол тэнцвэртэй тусгалаа гэж үздэг бөгөөд дундаж байр суурийг илэрхийлэхгүй үлдээдэг. Харин иргэний сэтгүүл зүй бол өөр юун дээр нэгдэж зөвшилцөхийг гол болгодог буюу ямар нэгэн асуудал, зөрчлийг тойруулан шуугиан дэгдээхээс илүү шийдвэрлэх арга замыг хэлэлцүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг учир уламжлалт сэтгүүл зүйг бодвол үр нөлөө нь илүү байдаг байна. Учир нь иргэдийн хувьд өөрсдийг нь хүрээлж буй орон нутгийн амьдрал тэдэнд илүү хамаатай, илүү ашигтай, үр нөлөөтэй байдаг ажээ.

Энэ талаар шинжлэх ухааны доктор, профессор М.Зулькафиль "...Сэтгүүл зүйн ОНМХ-ийн хамтын ажиллагааны нэг хэлбэр бол хувь хүн гэр бүлийн сонголт хийсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хооронд явагддаг. Хувь хүний хүсэл

сонирхол, хэрэгцээ шаардлагыг тэргүүн зэрэгт тавьдаг иргэний нийгмийн хувьд ийм төрлийн харилцан үйл ажиллагаа бол олон нийтийн мэдээллийн хүрээн дэх сэтгүүл зүйн үйл ажиллагааны ардчилал болон үр нөлөөний зайлшгүй нөхцөл мөн..."⁵ гэж оновчтой дүгнэсэн байдаг. Тиймээс ОНМХ-үүд оршин тогтнохын тулд хирдхиймээр гарчиг, сенсаци, хувийн амьдрал, хов жив хөөсөн нийтлэл, ярилцлага, нүцгэн хүүхэн, элдэв гэмт хэрэг зэргээр олон нийтийн санаа бодлыг татаж оршин тогтнох боломжгүй бөгөөд харин иргэд буюу уншигч, үзэгч, сонсогчидтой тогтоосон дотно харилцаа, иргэдийн дуу хоолойг сонсдог, түгээдэг хэвлэл мэдээллийн байгууллагууд оршин тогтнох болно.

Иргэний сэтгүүл зүйн "Пию төв"-өөс гаргасан гарын авлагад иргэний сэтгүүл зүйгээр ажилладаг сэтгүүлч, редакторууд өөрсдийн ажилд нь хэрхэн тус болж, ажилд нь ямар нөлөө үзүүлсэн тухай хэлснийг оруулсан байна. Энэ бүхнээс иргэний сэтгүүл зүй нь иргэдэд ямар нөлөө үзүүлж болохыг харж болно. Тухайлбал, Сан Францискогийн KQED FM радиогийн мэдээний найруулагч Раул Рамирес иргэний сэтгүүл зүйн үр нөлөөний тухай дараах жишээг хэлж байна. Тэрээр: "Зарим тохиолдолд сэтгүүлчдийг эрх баригчдын холбоо хамсаатан хэмээн үздэг. Энэ нь бид

мэдээллийг түргэн хугацаанд хүмүүст хүргэхийн тулд засгийн газар буюу томоохон компаниудаас мэдээлэл авч цацдагтай ч холбоотой байж магадгүй.

Харин иргэний сэтгүүл зүй гэдэг нь дээрх үзэл бодлоос тэс өөр юм. Бид мэдээллийг гаднаас цуглуулж, олон нийтийн санал бодлыг эрх баригчдад хүргэх үүрэгтэй. Жишээлбэл KQED нь өөр нэг мэдээллийн байгууллагатай хамтран нийтийн тээврийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж

чадсан. Ердийн үед бол бид тээврийн байгууллагууд, тэднийг эсэргүүцэж буй бүлгүүд болон танил талаасаа л мэдээлэл авдаг. Харин энэ удаад бид жил шахам хотын иргэдийн уулзалтуудыг зохион байгуулж, нийтийн тээврийн асуудал хэр нарийн төвөгтэй байдгийг ойлгож мэдсэн. Ингэс-

нээр бид илүү ухаалаг болж, мэдээллийн эх сурвалжуудаа нэмэгдүүлж, зөв асуултуудыг тавьж сурч, уламжлалт аргаар хүрч чадахгүй байсан төвшинд нийтлэлээ аваачсан. Мөн санал бодлыг нь бусдад сонсгосноор хүмүүсийн итгэлийг олж авч чадсан.

Иргэний сэтгүүл зүйн төлөө шүүмжлэлтэй хандах, нийтлэлээ сонирхолтой болгохыг эрмэлзэх гэсэн сэтгүүл зүйн уламжлалт зарчмуудаасаа бид татгалзаагүй. Харин уламжлалт аргаа сайжруулах арга замуудыг олж авсан. Ингэснээр

«
Тиймээс ОНМХ-үүд оршин тогтнохын тулд хирдхиймээр гарчиг, сенсаци, хувийн амьдрал, хов жив хөөсөн нийтлэл, ярилцлага, нүцгэн хүүхэн, элдэв гэмт хэрэг зэргээр олон нийтийн санаа бодлыг татаж оршин тогтнох боломжгүй бөгөөд харин иргэд буюу уншигч, үзэгч, сонсогчидтой тогтоосон дотно харилцаа, иргэдийн дуу хоолойг сонсдог, түгээдэг хэвлэл мэдээллийн байгууллагууд оршин тогтнох болно.

»

бидний ажилд итгэх ард иргэдийн итгэл нэмэгдсэн. Хүмүүс биднийг эрх мэдэлтнүүдийн хамсаатан бус, харин үнэн мөнийг эрэлхийлдэг хэнтэй ч болов түншлэхэд бэлэн гэдгийг ойлгосон"⁶ гэж хэлсэн нь иргэний сэтгүүл зүйн бодит нөлөөг харуулж байгаа юм. Иргэдийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлж, тэднийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцдог болгох нь гол үр дүн байх болно.

Мөн иргэний сэтгүүл зүйн үр нөлөөний тухай Америкийн мэдээллийн агентлагаас гаргасан "Ардчилал гэж юу вэ" гарын авлагад "Хэвлэлийн сүүлийн үед өсч байгаа өөр нэг үүрэг нь "хэлэлцэх асуудлын төсөл"-ийг гаргах явдал юм гэж тайлбарлагчид үзэж байна. Өөрөөр хэлбэл сүүлийн үед юу анхаарал татсан байна, юу нь сонирхолтой биш вэ гэдгийг шийддэг. Чухам үүгээрээ л ямар асуудал нэн чухал болоод байгаа талаар олон нийтийн санал сэтгэгдлийг бүрдүүлэхэд хэвлэлүүд нөлөөлдөг байна" гэж дурджээ.

Энэ мэтээр иргэний сэтгүүл зүйн үр нөлөө, нөлөөлөх чадвар олон янз бөгөөд хамгийн гол нь иргэдэд өөрсдөд нь хамаатай, шийдвэрлэх асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр өргөн хэлэлцэх замаар эрх ашигт нь нийцсэн зөв шийдвэрийг төр засгаас гаргахад нь нөлөө үзүүлдэг байна. Ингэснээрээ иргэдэд өөрийн сонгосон улс төрчдийн амлалтаа хэрхэн биелүүлж буйг хянаж, хариуцлагагүй ажиллаж буй бол шаардлага тавьж, төр засгийн бодлого, шийдвэр буруу бол шүүмжилж, эсэргүүцлээ илэрхийлэх боломжийг олгодог юм.

6. Дүгнэлт

Иргэд нийгмийн амьдралд мэдээлэлтэй оролцож, төрийн эрх барилцах эрхээ эдлэхэд төр засаг ч,

иргэд ч үүрэг, хариуцлагатай байх ёстой юм. Энэхүү хариуцлагыг ухамсарлуулахад ч иргэний сэтгүүл зүйн ач холбогдол, үр нөлөө чиглэгддэг гэж хэлж болно. Эцэст нь дүгнэж хэлэхэд Монголд иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэхэд тодорхой бодлого, дэс дараатай арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд иргэдийг өөрсдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхэд идэвхтэй оролцдог, иргэний мэдээлэл түгээх эрхээ эдэлж чаддаг болгох, хариуцлагатай байх зэрэгт сургахад иргэний сэтгүүл зүйг чиглүүлж, нөлөөлөх нь чухал зорилтын нэг юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүлээн авагч буюу уншигч, сонсогч, үзэгчидтэйгээ тогтоосон харилцааны үндсэн дээр тэдэнд ямар мэдээлэл хэрэгтэйг мэдсэнээр тэдний хүссэн мэдээллийг дамжуулж, иргэдийн нийгэмд хандах идэвхийг сэргээх нь Иргэний сэтгүүл зүйн зорилго болж байна.

Ишлэл

- ¹ 2002. Сайн засаглалын зарим нэр томъёоны тайлбар. УБ. Х. 34.
- ² Н о р о в с ү р э н Л. 2001. Иргэний сэтгүүл зүйн онолын зарим асуудалд. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. №181(10). "Сэтгүүл зүй". Х. 19.
- ³ Civic journalism is... 1999. Center for Civic Journalism. Washington. P. 4.
- ⁴ Н о р о в с ү р э н Л. 2001. Иргэний сэтгүүл зүйн онолын зарим асуудалд. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. №181(10). "Сэтгүүл зүй". Х. 16.
- ⁵ З у л ь к а ф и л ь М. 2000. Сэтгүүл зүйн онолын үндэс. Дэд дэвтэр. УБ. Х. 60.
- ⁶ Civic journalism is... 1999. Center for Civic Journalism. Washington. P. 9.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- 1 1991. Ардчилал гэж юу вэ? Америкийн мэдээллийн агентлаг.
- 2 2001. Америкийн ОНМХ-ийн тойм. Эрх. Д.Цэрэнжав. №09-10 (12-13).
- 3 2002. Мэдээллийн эрх чөлөө. Эмхэтгэл. УБ.
- 4 З у л ь к а ф и л ь М. 2000. Сэтгүүл зүйн онолын үндэс. Дэд дэвтэр. УБ.
- 5 З у л ь к а ф и л ь М., Ч о й с а м б а Ч. 2001. Чөлөөт хэвлэл: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
- 6 Н о р о в с ү р э н Л. 2001. Иргэний сэтгүүл зүйн онолын зарим асуудалд. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. №181(10). "Сэтгүүл зүй".
- 7 1992. Монгол улсын үндсэн хууль. УБ.
- 8 М е н ч е р М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.

- 9 Civic journalism is... 1999, Center for Civic Journalism. Washington.
- 10 2002. Сайн засаглалын зарим нэр томъёоны тайлбар. УБ.

Резюме

В данной статье затрагиваются некоторые проблемы журналистики на современном этапе развития демократии и аспекты участия граждан в созидании гражданского общества. Автор считает необходимым специально исследовать проблему гражданской журналистики, так как её значимость в последние годы неуклонно возрастает. В конце статьи автор высказывает свои соображения на счёт создания благоприятных условий для развития гражданской журналистики.